



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14.2.3, 14.2.5 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:


1. Алслагдсан нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнуудын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зайн сургалтын медиа орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

2. Зайн сургалтын медиа орчин бүрдүүлэхэд шаардагдах зардлыг Анагаахын шинжлэх ухааны их сургуулиас шилжүүлсэн 180 сая төгрөгийн сургалтын зардлаас санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Ч.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Зайн сургалтын медиа орчин бүрдүүлэхтэй холбоотой худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, 2015 оны III улиралд багтаан ашиглалтад оруулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвд эрх шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

090808